

## ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

*Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт,  
өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар*

Монгол Улсад 1990 онд олон намын оролцоотой анхны чөлөөт, ардчилсан сонгууль болж Ардын Их Хурлын депутатуудыг ард иргэд нийтээрээ, чөлөөтэй, ардчилсан зарчмын дагуу сонгож, Ардын Их Хурлыг шинэчлэн байгуулсан. Анх удаа ардчилсан, чөлөөт өрсөлдөөний үндсэн дээр сонгогдсон иргэдийн төлөөллөөс бүрдсэн Ардын Их Хурал “БНМАУ-ын үндсэн хуулийн нэмэлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай” хууль баталж, уг хуулийн дагуу хууль тогтоох, хянан шалгах, зохион байгуулах эрх бүхий төрийн эрх барих байнгын дээд байгууллага болох Улсын Бага Хурлыг 50 гишүүнтэйгээр байгуулсан. Үүний үр дүнд Монгол Улсын Үндсэн хуулийг 1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр баталж, өнөөдрийг хүртэл хүчин төгөлдөр мөрдөж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна...” гэж, Хорин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална” гэж тус тус заасны дагуу засгийн бүх эрх ард түмний мэдэлд тул сонгогчид өөрсдийн төлөөлөл болсон Улсын Их Хурлын гишүүнийг бүрэн эрхийн хугацаанаас нь өмнө эгүүлэн татах бүрэн эрхтэй юм.

Түүнчлэн 2019 оны Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Хорин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өргөсөн тангаргаасаа няцаж Үндсэн хууль зөрчсөн бол түүнийг Улсын Их Хурлын гишүүнээс эгүүлэн татах үндэслэл болно.” гэсэн нэмэлтийг оруулсан нь ардчилсан парламентын улсад томоохон дэвшил болсон.

Гэвч Улсын Их Хурлын гишүүнийг өргөсөн тангаргаасаа няцаж, үндсэн хууль зөрчсөн гэсэн үндэслэлээр эгүүлэн татсан тохиолдол өмнө нь гараагүй бөгөөд 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтөөс хойш Үндсэн хуулийн цэцэд гишүүнийг эгүүлэн татахтай холбоотой маргаан үүсэж байгаагүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд 1992 оноос 2026 оны 1 дүгээр сар хүртэлх хугацаанд Монгол Улсын Их Хурлын гишүүн Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлаар давхардсан тоогоор 223 өргөдөл, мэдээлэл, гомдол, хүсэлт ирүүлснийг шалган шийдвэрлэж, 7 дүгнэлт, 22 магадлал, 127 маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзсан тогтоол гаргажээ.<sup>1</sup>

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын судалгаанд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээс Улсын Их Хурлын даргыг Үндсэн хууль зөрчсөн, огцруулах үндэслэлтэй гэсэн дүгнэлт гарч байсан ч уг цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хэлэлцэн цэцийн дүгнэлтийн дагуу огцруулах шийдвэр гаргаж байгаагүй нь Үндсэн хуулийн цэцийн шийдвэр эцсийн шийдвэр байх зарчмыг зөрчсөн төдийгүй Улсын Их Хурлын тухай хуулийн холбогдох хэсгийг Үндсэн хуульд нийцүүлэх хэрэгцээ шаардлага байгаа болохыг дурдсан байна.

---

<sup>1</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын 2026 оны 1 сарын 26-ны өдрийн албан бичиг

Түүнчлэн Улсын Их Хурлын 2016 оны ээлжит сонгуулийн үр дүнд байгуулагдсан Улсын Их Хурлын 76 гишүүний нэг гишүүн “хүчиндэх” гэмт хэрэгт, нэг гишүүн авлига албан тушаалын гэмт хэрэгт холбогдон өөрийн хүсэлтээр тус тус чөлөөлөгдсөн. Харин нэр бүхий 5 гишүүн Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас нэн хөнгөлөлттэй зээлийг эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглан бусдад давуу байдал бий болгон олгосон зэрэг гэмт хэрэгт холбогдсон ба Улсын Их Хурлын гишүүнээс чөлөөлөгдөөгүй байдаг.

Дээрхээс үзвэл Улсын Их Хурлын гишүүний хувиар хуулийн хариуцлага хүлээсэн тохиолдол байхгүй байх төдийгүй Улсын Их Хурлын гишүүнийг Үндсэн хууль болон бусад хуулийг зөрчсөнтэй холбогдуулан иргэд өргөдөл, мэдээлэл гарган шийдвэрлүүлэх эрх зүйн орчин хязгаарлагдмал, Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн зарим зохицуулалт хэрэгжихгүй үхмэл болж байна.

Монгол Улсын Их Хурлын гишүүний үйл ажиллагаатай холбогдуулан Улсын Их Хурлын Ёс зүй, сахилга, хариуцлагын байнгын хороонд 2020 оноос 2024 онд нийт 18 шаардлага, өргөдөл, гомдол ирүүлсэн байх бөгөөд ёс зүйн шаардлагатай холбоотой 11, ашиг сонирхлын зөрчилтэй холбоотой 3, хөрөнгө орлогын мэдүүлэгтэй холбоотой 2, сонгуулийн сурталчилгаатай холбоотой 2 гомдол бүртгэгдсэн байна.<sup>2</sup> Дээрх шаардлага, өргөдөл, гомдолд Улсын Их Хурлын гишүүн ёс зүйгүй авирласан учир хариуцлага тооцож, арга хэмжээ авахыг олон нийт шаардсан, хүний эрхэд халдсан байж болзошгүй, нэр бүхий гишүүд албан тушаалын байдлаа ашиглан ёс зүйгүй үйлдэл гаргасан зэргийг дурдсан ба хэрхэн яаж шийдвэрлэсэн талаар олон нийтэд нээлттэй бус байгаа нь парламентын үйл ажиллагаанд хяналт тавих, хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчин хангалтгүй байгаагийн илрэл болж байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалтыг хэлбэрийн төдий бус амьтай болгох зорилгоор Үндсэн хууль болон бусад хуулийг дээдлэн сахих үүргийг нэмэлтээр орууллаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Үндсэн хуулийн цэц энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр дараахь маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулна: 1/хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх; 2/ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх; 3/Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор Үндсэн хууль зөрчсөн эсэх; 4/Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг огцруулах, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх.” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Энэ зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2-т заасны дагуу оруулсан дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөөгүй бол Үндсэн хуулийн цэц дахин хянан үзэж эцсийн шийдвэр гаргана.” гэж тус тус зааснаас үзэхэд Улсын Их Хурал нь зөвхөн Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2-т заасны дагуу оруулсан дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх эсэх

---

<sup>2</sup> Монгол Улсын Их Хурлын Ёс зүй, дэгийн байнгын хорооны даргын 2024 оны 8 сарын 26-ны өдрийн УИХ-07/2032 дугаар албан бичиг

асуудлыг хэлэлцэхээр заасан бөгөөд 2 дахь хэсгийн 3, 4-т заасан асуудлаар Үндсэн хуулийн цэц эцсийн дүгнэлт гаргахаар хуульчилжээ.

Гэтэл Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-т “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц гишүүнийг тангаргаасаа няцаж Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн гэсэн дүгнэлт гаргасныг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн бол түүнийг эгүүлэн татах эсэх асуудлыг Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэнэ.” гэж заасан бөгөөд уг агуулга бүхий зохицуулалтыг Улсын Их Хурал 2006 оноос хойш мөрдөж ирсэн нь Үндсэн хуульд заасан зарчмыг зөрчиж, Үндсэн хуулийн цэцийн эрх хэмжээнд халдсан гэж үзэхээр байна.

Мөн Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4-т гэмт хэрэг үйлдсэн нь хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрээр тогтоогдсон тохиолдолд гишүүнийг эгүүлэн татах асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэхээр заасан байгаа нь Үндсэн хуульд нийцээгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2007 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн 03 дугаар тогтоолоор Улсын Их Хурлын дарга Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэж, Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн<sup>3</sup> гэж дүгнэснийг Улсын Их Хурал хүлээн аваагүй байх бөгөөд 2007 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн нэр бүхий 2 иргэнээс ирүүлсэн өргөдлийн дагуу Үндсэн хуулийн цэц маргаан үүсгэж, мөн оны 5 дугаар сарын 23-ны өдрийн Үндсэн хуулийн цэцийн Их суудлын хуралдаанаар хэлэлцэн Улсын Их Хурлын даргыг Үндсэн хуулийн холбогдох зүйл, заалтыг зөрчсөн, “... Улсын Их Хурлын дарга Улсын Их Хурлын бүрэн эрхэд удаа дараа халдаж, Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн үйлдэл нь түүний Улсын Их хурлын даргын албан тушаалаас огцруулах үндэслэл болно”<sup>4</sup> хэмээн дүгнэж байжээ.

Энэ нь Үндсэн хуулийн цэцийн шийдвэр биелэгдэхгүй, Үндсэн хуульд ёс хэрэгжихгүй байгааг илтгэж байх бөгөөд парламентын гишүүн өргөсөн тангаргаасаа няцаж, Үндсэн хууль зөрчсөн нь Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтээр, гэмт хэрэг үйлдсэн болох нь хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрээр тогтоогдсон ч эгүүлэн татах боломжгүй нөхцөлд байгаа нь ардчилсан улсын механизмаас нэг алхмаар ухарч байгаагийн илрэл болж байна.

Иймд хууль дээдэлдэггүй, нийтийн эрх ашгийг умартдаг, Үндсэн хууль болон бусад хуулийг зөрчсөн, өргөсөн тангаргаасаа няцсан Улсын Их Хурлын гишүүнд бодитой хариуцлага хүлээлгэх, эгүүлэн татах, парламентыг ард түмэн засаглах эрх зүйн зохицуулалтыг сайжруулах зайлшгүй шаардлагатай байна.

Хуулийн төсөл нь нийт 6 зүйлтэй бөгөөд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн зарим зүйл, заалтыг Үндсэн хуульд нийцүүлэх замаар парламентыг ард түмэн засаглах эрхийг бэхжүүлж, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт заасны дагуу Улсын Их Хурлын гишүүдийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт тавих, шаардлагатай тохиолдолд хуульд заасны дагуу эгүүлэн

---

<sup>3</sup> Монгол улсын Үндсэн хуулийн Цэцийн 2007 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн 03 дугаар дүгнэлт, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=1100>

<sup>4</sup> Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн 2007 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн 06 дугаар дүгнэлт, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=1101>

татах улс төрийн эерэг соёл, хандлагыг төлөвшүүлэх зохицуулалтын орчныг сайжруулах агуулгатай болно.

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн зарим зүйл, заалт Үндсэн хуульд нийцэж, Үндсэн хуулийн зөрчил арилах бөгөөд иргэд, сонгогчид өргөсөн тангаргаасаа няцаж, Үндсэн хууль зөрчсөн Улсын Их Хурлын гишүүнд холбогдуулан Үндсэн хуулийн цэцэд өргөдөл, мэдээлэл гаргах хүрээ хязгаар нэмэгдсэнээр парламентыг ард түмэн засаглах эрх нээгдэж, Улсын Их Хурлын гишүүдэд хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчин сайжирч, хууль дээдлэх зарчим бодитойгоор биелэгдэх төдийгүй Үндсэн хуулийн цэц болон шүүхийн шийдвэр нь эцсийн байх зарчим бүрэн утгаараа хэрэгжинэ.

Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээр болон бусад хууль тогтоомжтой нийцэх бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хамтад нь өргөн мэдүүлнэ.

---oOo---